

ШАР УСАН ӨВЧНИЙ АА ХЭЛБЭРИЙН ЭМГЭГ ЗАГВАРИЙН ТУРШИЛТ СУДАЛГАА¹Цэлгэр, ¹С.Пүрэвсүрэн, ²Ариунаа, ²Рашнамжил¹Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Эм зүйн сургууль²Өвөр Монголын Үндэстний их сургуулийн Монгол Эм Эмнэлгийн дээд сургууль

qirigeer@163.com

EXPERIMENTAL STUDY OF AA TYPES MODEL OF THE YELLOW FLUID DISEASE^{1,2}Qirigeer, ¹Purevsuren.C, ²Ariunaa, ²Rashnamjil¹Mongolian National University of Medical Sciences²Inner Mongolia University for Nationalities of Mongolian Medicine College

qirigeer@163.com

Abstract

A yellow-fluid disease is a long-term disease that is common among Mongolians. A treatment of yellow fluid disease has an important place in Mongolian traditional medicine, and it is very complex condition due the continuous environmental and the climate change as well as overall evolving of other diseases. Rheumatoid arthritis (RA) is one of the most common disease with complex systemic nature and caused by autoimmune disorders.

This article is about inflammatory design of an affiliated member. The experiment was carried on rats, divided into two groups: healthy control groups and study groups. RA was developed in a study group rats and carefully observed. Rheumatism swelling level of rats were measured for 50 days. The result of the observation is the maximum swelling of study group were at third and thirty first days, and the swelling is slowly reduced until day 50, when the rheumatoid-inflammatory were healed. The aim of this study is to set the basis for future yellow-fluid disease study.

Key words: Yellow fluid diseases; Rheumatoid arthritis, AA types model

Удиртгал: Монгол анагаах ухаанд шар усыг тамирын хэвчээнд багтаадаг, шар ус бол долоон тамирын бүтэх хувирах явцын дунд цусны тунгалаг мах болж, цусны цөв нь цөс болж цөсний тунгалаг нь шар ус болж бүх биед тархдаг бөгөөд шар ус хэвийн үед хүний биеийн арьс хөрсийг зөөлрүүлэх, үе гишүүг гулгамтгай зөөлөн болгох, уян хатан чанарыг баталж, биеийн эрүүл үе гишүүний хөдөлгөөнийг батлах үйлдэлтэй. Хэрвээ дүр урвабал хүний бие махбодыг нөлөөлөх буюу хөнөөх юм[1]. Шар усан өвчин нь Монгол анагаах ухаанд чухал байрыг эзэлдэг төдийгүй, байгаль орчин ба цаг уурын тасралтгүй хувиралт, хүн төрөлхтний өвчин эмгэгийн тасралтгүй хувиралт зэргийг дагалдан шар усан өвчин нь нарийн будлиантай, хүрээ хэвчээ нь нэн

өргөн дэлгэрэнгүй болж өдрөөс өдөрт олон судлаачид ба мэргэжилтнүүдийн анхаарлыг татаж байна[2]. Шар усан өвчнийг нэн гүнзгий танихын хамт орчин үеийн анагаах ухааны арга барилаар судалбал эмчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх болно. Иймээс тус судалгаагаар харханд үе гишүүний шар усан өвчний эмгэг загвар үүсгэх туршилт судалгаа хийсэн байна. RA (rheumatoid arthritis)-ийн эмгэг загварыг АА (Adjuvant Arthritis) ба СІА (Collagen Induced Arthritis) -ийн хоёр хэлбэрээр үүсгэдэг байна. СІА загвар бол СІІ ба ІFА буюу СFА-ийг уялдуулан хархны биенд өдөөн үүсгэсэн амьтны эмгэг загвар болно. СІІ бол мөгөөрсөн ясны гол бүрэлдэхүүн байж, үе гишүүний өвчлөхтэй нягт холбогдолтой онцлогтой эсрэг төрөгч болно. RA ба СІА эмгэг загварын амьтны




Figure 1. The alteration of rat's footprints tumor for 50-day

Хэлцэмж: Хэрх чанартай үе гишүүний үрэвсэл (RA) бол нэг зүйлийн ядаргаа ба ойр орчмын үе гишүүнээр гол болгосон олон систем чанартай өөрийн биеийн дархлааны чадамжийн өвчин байж, эмчилгээн дээр үргэлж тохиолддог өвчний нэг болно. Өвчний илрэлийн онцлог нь тэгш хэмт чанартай, ойр хавийн олон үе гишүү нь аажмаар үрэвслийн чанартай өвчний хувиралд орж, их ядрах, үе гишүү нь хатгалж өвдөх, хавдах, үйл ажиллагааны чадамж нь буурах юм. Өвчин дахин дахин хөдлөх ба зэрэмдэг болох эрсдэл туйлын өндөр байдаг (40%-аас дээш хүрнэ). Хэрх чанартай үе гишүүний үрэвсэлт өвчин нь дэлхий нийтээр тархаж, БНХАУ-д өвчлөлийн тархалт 0.32%-0.36% болсон ба БНХАУ-ын хүмүүсийн хөдөлмөрийн чадвараа алдаж, зэрэмдэг болж байгаа гол шалтгааны нэг болно [4,5]. Ийм учраас бид АА хэлбэрийн эмгэг загварыг судлах нь чухал холбогдолтой гэж үзэж байна.

Дүгнэлт: Дээрх үр дүнд үндэслэж эм өгөх өдрийг 31 өдөрт тохируулах нь зүйтэй гэж үзэж байна. Туршилтийн 31-50 дах өдрүүдэд хавдрын хэмжээ буурсан нь хархны үе гишүүний үрэвслийн өөрөө эдгэрч байгаа байдал гэж үзэж болно. Тус судалгаагаар дамжин эм өгөх өдрийг тогтоож хэрх чанартай үе гишүүний үрэвсэлт өвчин буюу шар усан

өвчний цаашдын судалгааны суурийг тавив.

Ном зүй:

1. “Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь” найруулах комисс, Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь, Монгол анагаах ухаан, [М] Өвөр Монголын шинжлэх мэргэжлийн хэвлэлийн хороо, 1986
2. Хангайбаатар, Шар усан өвчний судлал [М]. Хөххот: Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2007:1-3
3. 杨怡坤,胡荫奇.类风湿性关节炎的发病机理探讨[J].中国骨伤,2000(05):22-24
4. 胡吴斌,胡玲,唐照亮,等.类风湿性关节炎实验动物模型研究与评述[J].中国中西医结合杂志,2011,31(9):1290-1292
5. 李颖,汪悦,覃仕化.类风湿性关节炎的研究进展[J].中国矫形外科杂志, 2011, 19(7):581-584

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
АУ-ы доктор Э.Энхсүрэн*